ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЖАРГАЛАНТ СУМЫН 11 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/169 /СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Ховд хот
2021 он


Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn
Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК
Аудитор: Д.Хишгээ
Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com


*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу*

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....**Error! Bookmark not defined.**
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....8
3. Аудитын тайлан ....8
3.1. Ерөнхий зүйл ....9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....10
3.4. Материаллаг байдал ....10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....12
3.7. Шилэн дансны мэдээлэл....13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14
3.9. Аудитын илрүүлэлт....14
Залруулсан алдаа ....14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....14
Аудитын зөвлөмж ....14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....14
4. Менежментийн захидал ....14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....15

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ. ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/104

танай ____________-ны №____________-т

ЖАРГАЛАНТ СУМЫН 11ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ц.ТУЛГА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ард иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, үндэсний язгуур өв соёлоо түгээн дэлгэрүүлэх ажлын хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

2010004

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31 758 546.5** | **41 379 546.5** |
| **33** | **АВЛАГА** | 37 287.0 | 2 214 560.0 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 37 287.0 | 2 214 560.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31 721 259.5 | 39 164 986.5 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 475 000.0 |
| 35130 | Эм боох материал | - | 475 000.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 31 721 259.5 | 38 689 986.5 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 163 400.0 | 175 700.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 159 500.0 | 4 557 500.0 |
| 35460 | Хүнсний материал | 1 040 484.5 | 3 598 911.5 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 30 357 875.0 | 30 357 875.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **926 491 277.9** | **897 662 387.8** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 926 491 277.9 | 897 662 387.8 |
| **392** | **Биет хөрөнгө** | 858 382 877.9 | 829 553 987.8 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 848 189 794.1 | 848 189 794.1 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (27 348 850.3) | (53 617 700.6) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 52 006 455.3 | 56 205 335.3 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27 444 838.0) | (32 496 526.2) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29 402 218.2 | 29 841 314.6 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18 585 901.4) | (20 738 229.4) |
| 39217 | Ном | 2 164 000.0 | 2 170 000.0 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 68 108 400.0 | 68 108 400.0 |
| 39301 | Програм хангамж | 275 000.0 | 275 000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (275 000.0) | (275 000.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 68 108 400.0 | 68 108 400.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **958 249 824.4** | **939 041 934.3** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **77 232.0** | **3 841 905.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 77 232.0 | 3 841 905.0 |
| **413** | **Өглөг** | 77 232.0 | 3 841 905.0 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 76 432.0 | 3 841 105.0 |
| **4136** | **Бусад өглөг** | 800.0 | 800.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 800.0 | 800.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **958 172 592.4** | **935 200 029.3** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 958 172 592.4 | 935 200 029.3 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 229 233 534.0 | 229 233 534.0 |
| 51101 | Өмч: - төрийн | 229 233 534.0 | 229 233 534.0 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 152 826 312.6 | 129 853 749.6 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 152 826 312.6 | 152 826 312.6 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (22 972 563.0) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 576 112 745.8 | 576 112 745.8 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **958 249 824.4** | **939 041 934.3** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **373 326 146.5** | **419 967 325.4** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20 242 867.5** | **3 938 096.4** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 7 582 799.0 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7 582 799.0 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7 582 799.0 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **122** | **Тусламжийн орлого** | 12 660 068.5 | 3 938 096.4 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 1 377 817.2 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 11 282 251.3 | 3 938 096.4 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **353 083 279.0** | **416 029 229.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 348 263 300.0 | 410 436 200.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 48 622 000.0 | 63 117 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 299 641 300.0 | 347 319 100.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 5 593 029.0 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 5 593 029.0 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4 819 979.0 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4 819 979.0 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **382 444 722.7** | **442 939 888.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **382 444 722.7** | **442 939 888.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 377 624 793.7 | 431 840 959.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 222 854 945.0 | 283 487 351.0 |
| 210101 | Үндсэн цалин | 197 884 552.0 | 265 454 375.0 |
| 210102 | Нэмэгдэл | 6 011 311.0 | 6 155 250.0 |
| 210104 | Урамшуулал | 18 959 082.0 | 11 877 726.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27 541 520.0 | 35 251 362.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18 939 290.8 | 24 320 075.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2 223 681.9 | 2 732 846.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1 772 118.6 | 2 186 457.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 418 766.3 | 546 389.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4 187 662.5 | 5 465 593.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44 879 723.0 | 46 009 934.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2 994 012.0 | 2 593 502.0 |
| 210302 | Түлш, халаалт | 32 199 911.0 | 30 652 580.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9 685 800.0 | 12 763 852.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1 477 479.0 | 2 028 161.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 393 500.0 | 1 157 200.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41 600.0 | 166 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 293 902.0 | 445 286.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 748 477.0 | 18 000.0 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 241 575.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 49 570 423.5 | 23 520 156.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25 000.0 | 1 180 150.0 |
| 210502 | Хоол, хүнс | 48 515 428.5 | 21 855 817.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1 029 995.0 | 484 189.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 109 600.0 | 7 338 529.0 |
| 210604 | Урсгал засвар | 109 600.0 | 7 338 529.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 183 200.0 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 183 200.0 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 200 000.0 | 432 000.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200 000.0 | 432 000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30 807 903.2 | 33 773 466.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303 200.0 | 300 600.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30 504 703.2 | 33 472 866.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4 819 929.0 | 11 098 929.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4 819 929.0 | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4 819 929.0 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 11 098 929.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 11 098 929.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(9 118 576.3)** | **(22 972 563.0)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(9 118 576.3)** | **(22 972 563.0)** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **353 083 279.0** | **416 029 229.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **353 083 279.0** | **416 029 229.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 348 263 300.0 | 410 436 200.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 48 622 000.0 | 63 117 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 299 641 300.0 | 347 319 100.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 5 593 029.0 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 5 593 029.0 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4 819 979.0 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4 819 979.0 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **353 083 279.0** | **416 029 229.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **353 083 279.0** | **416 029 229.0** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **348 263 350.0** | **404 930 300.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 224 155 200.0 | 279 683 400.0 |
| 210101 | Үндсэн цалин | 163 304 851.0 | 177 377 467.2 |
| 210102 | Нэмэгдэл | 44 356 849.0 | 80 076 199.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2 210 500.0 |
| 210104 | Урамшуулал | 16 493 500.0 | 20 019 233.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26 299 550.0 | 37 491 700.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17 639 800.0 | 26 304 300.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2 361 350.0 | 2 796 900.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1 535 600.0 | 2 237 400.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 433 000.0 | 559 400.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4 329 800.0 | 5 593 700.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45 513 200.0 | 50 424 009.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2 994 012.0 | 2 782 502.0 |
| 210302 | Түлш, халаалт | 32 199 911.0 | 34 830 555.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10 319 277.0 | 12 810 952.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 818 153.0 | 631 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 377 651.0 | 154 500.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51 900.0 | 92 600.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 293 902.0 | 98 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 68 300.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 94 700.0 | 217 600.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 47 494 200.0 | 27 657 000.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25 000.0 | 1 211 500.0 |
| 210502 | Хоол, хүнс | 46 435 000.0 | 25 594 400.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1 034 200.0 | 851 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3 108 800.0 | 1 831 913.0 |
| 210604 | Урсгал засвар | 3 108 800.0 | 1 831 913.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 183 200.0 | 123 000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 183 200.0 | 123 000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 200 000.0 | 559 600.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 127 600.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200 000.0 | 432 000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 491 047.0 | 6 528 578.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12 300.0 | 5 593 029.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 478 747.0 | 935 549.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4 819 929.0** | **11 098 929.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4 819 929.0 | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4 819 929.0 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 11 098 929.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 11 098 929.0 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 229 233 534.0 | 576 112 745.8 | 161 944 888.9 | 967 291 168.6 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **229 233 534.0** | **576 112 745.8** | **161 944 888.9** | 967 291 168.6 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (9 118 576.3) | (9 118 576.3) |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **229 233 534.0** | **576 112 745.8** | **152 826 312.6** | 958 172 592.4 |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **229 233 534.0** | **576 112 745.8** | **152 826 312.6** | 958 172 592.4 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **229 233 534.0** | **576 112 745.8** | **152 826 312.6** | 958 172 592.4 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (22 972 563.0) | (22 972 563.0) |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **229 233 534.0** | **576 112 745.8** | **129 853 749.6** | 935 200 029.3 |

## 2.5 **АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **410436200.0** | **399337271.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 410436200.0 | 399337271.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 410436200.0 | 399337271.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 279683500.0 | 279683400.0 |
| 210101 | Үндсэн цалин | 172748200.0 | 177377467.2 |
| 210102 | Нэмэгдэл | 85360800.0 | 80076199.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2211000.0 | 2210500.0 |
| 210104 | Урамшуулал | 19363500.0 | 20019233.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37757400.0 | 37491700.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26570000.0 | 26304300.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2796900.0 | 2796900.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2237400.0 | 2237400.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 559400.0 | 559400.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5593700.0 | 5593700.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51046600.0 | 50424009.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2720800.0 | 2782502.0 |
| 210302 | Түлш, халаалт | 36382500.0 | 34830555.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11943300.0 | 12810952.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 596000.0 | 631100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 119500.0 | 154500.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 92500.0 | 92600.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 98100.0 | 98100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 68300.0 | 68300.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 217600.0 | 217600.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 37413000.0 | 27657000.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2207000.0 | 1211500.0 |
| 210502 | Хоол, хүнс | 34220100.0 | 25594400.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 985900.0 | 851100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2054400.0 | 1831913.0 |
| 210604 | Урсгал засвар | 2054400.0 | 1831913.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 123700.0 | 123000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 123700.0 | 123000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 575600.0 | 559600.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143600.0 | 127600.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432000.0 | 432000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1186000.0 | 935549.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1186000.0 | 935549.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **410 436 200.00** | **399 337 271.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 410 436 200.00 | 399 337 271.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 52 018 171.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 410 436 200.00 | 347 319 100.00 |

## 2.6 **АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

Тайлант онд нэмэлт дансаар орлого зардлын гүйлгээ хийгдээгүй болно.

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5 593 029.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5 593 029.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5 593 029.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5 593 029.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5 593 029.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Жаргалант сумын11 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шууд захирагч, цэцэрлэгийн Эрхлэгч Ц.Тулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд норматив зардал/хоол/, е баримтын бүрдүүлэлт, Нийгмийн даатгалын шимтгэл, унаа , хоол, түлшний хөнгөлөлтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25 -наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:

Тус цэцэрлэг нь 2020 онд ‘Хүүхдийн шүдний өвчлөлийг 35 хувь бууруулна ’’ зорилго дэвшүүлсэн байна. Энэхүү зорилгыг хангах чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- *Хамран сургах тойргийн болон бусад тойргийн тус цэцэрлэгт хамрагдах хүсэлтэй 5 настай хүүхдийг бүрэн хамруулах,*
- *”Олон нийтийн оролцоот сургууль,цэцэрлэг-Хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж цэцэрлэгийн үйл ажиллагаа, хүүхдийг бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх,асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлэх,*
- *Үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг хамтын оролцоотой хийж, үр дүнд суурилан менежмент,үйл ажиллагаагаа сайжруулах,*
- *Удирдах ажилтнуудын манлайллын ур чадварыг сайжруулах,төрөлжсөн сургалтад хамрагдах,*
- *Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын ба танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот ‘’Хоолны зардлын норматив тогтоох тухай’’*

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Тус байгууллага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна. Тухайн оны шилэн дансны мэдээллээ хугацаандаа оруулж улирал тутам тайлангаа илгээсэн тул зөрчил илрээгүй байна.

Сар бүр Жаргалант сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэхэд 99-100%аар дүгнэгдсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 314737,0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3147,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 2 хувиар 8399.3 мянган төгрөгөөр тооцлоо.

Алдааны дүн материаллаг бус /эрсдэл бага / үр нөлөөгүй цар тахлын үед ажилчдадаа олгосон унаа, хоол, түлшний урамшуулал нь олон хүнийг хамруулсан учраас дүн өндөр гарч буй учраас аудитын төлөвлөлтийн үед сонгосон МБ-түвшинг 2 хувь болгон өөрчилсөн бөгөөд тус алдааг материаллаг бус гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19208,7 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь |
| Б | 1 | 2 | 3=2-1 | |
| Авлага | 37.30 | 2 214.50 | - 2 177.20 | |
| Бараа материал | 31 721.30 | 39 164.90 | - 7 443.60 | -23.5% |
| Үндсэн хөрөнгө | 926 491.30 | 897 662.40 | 28 828.90 | 3.1% |
| **Нийт хөрөнгө** | **958 249.90** | **939 041.80** | 19 208.10 | 2.0% |
| Өр төлбөр | 77.20 | 3 841.10 | - 3 763.90 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 958 172.60 | 935 200.00 | 22 972.60 | 2.4% |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **958 249.80** | **939 041.10** | 19 208.70 | **2.0%** |

Авлага дансны үлдэгдэл 2214.5 мянган төгрөг болж 2177.2 мянган төгрөгөөр өссөн нь татвар ндш-ын тооцооллын зөрүүгээс гарсан авлага . Тус байгууллагуудтай тооцоо нийлж өглөг авлагаа баталгаажуулсан бөгөөд дараа онд бүрэн барагдах боломжтой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39164.9 мянган төгрөг болж 7443.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 39950.3 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч,32506.6 мянган төгрөгний зарлага гаргасантай холбоотой байна.

Эм боох материалын үлдэгдэл 475.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Хүнсний материалын үлдэгдэл 3598.9 мянган төгрөг байгаа МУ-ын боловсрол шинжлэх ухааны сайдын 2020-11-27-ны А/162 тоот тушаалаар тус цэцэрлэг хоол хүнс тэжээлийн дутагдалд өртөх эрсдэл бүхий өөрийн цэцэрлэгт хамрагддаг 9 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн орсон 137320 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 823920 төгрөгийн үнэ бүхий хоол хүнсийг 6 хүүхдэд олгосон байна.

Бичиг хэрэг 175.7, аж ахуйн материал 4557.6, бусад хангамжийн материал БҮТЭЗ 30357.9 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 897662.4 мянган төгрөг болж өмнөх оноос 4643.9 мянган төгрөгөөр өссөн БСУГ-аас 2 ш нөөтбүүк хөрөнгө оруулалтаар ирснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3499.0 мянган хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 107127.5 мянган төгрөг байснаас тайлант онд 33472.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна. Тус байгууллага өр төлбөр дансны үлдэгдэлгүй . Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 935200.0 мянган төгрөг болж 22972.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 46641.2 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 47677.8 мянган төгрөгийн орлого нь өмнөх оноос тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | зөрүү |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **373 326.1** | **419 967.3** | - 46 641.2 |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20 242.9** | **3 938.1** | 16 304.8 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7 582.8 | - | 7 582.8 |
| **Тусламжийн орлого** | 12 660.1 | 3 938.1 | 8 722.0 |
| Хандив тусламж /дотоод/ | 1 377.8 | - | 1 377.8 |
| Хандив тусламж /гадаад/ | 11 282.3 | 3 938.1 | 7 344.2 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 48 622.0 | 63 117.1 | - 14 495.1 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 299 641.3 | 347 319.1 | - 47 677.8 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 5 593.0 | - 5 593.0 |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4 820.0 | - | 4 820.0 |

Нийт зардал өмнөх оноос 60495.2 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 60632.4, нийгмийн даатгалын шимтгэл 7709.8, байр ашиглалттай холбоотой

тогтмол зардлууд 1130.2, бараа үйлчилгээний бусад зардал 2965.6 , буцаан төвлөрүүлсэн 11089.9.мянган төгрөгөөр тус зардлууд байна.

Энэ нь өмнөх оноос цалин хөлсний зардалд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинээр тооцогдон олгогдсон, төсвийн хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

| | | | | |
|---|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **382 444.7** | **442 939.9** | - | 60 495.2 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 222 854.9 | 283 487.4 | - | 60 632.4 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27 541.5 | 35 251.4 | - | 7 709.8 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44 879.7 | 46 009.9 | - | 1 130.2 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 1 477.5 | 2 028.2 | - | 550.7 |
| **Норматив зардал** | 49 570.4 | 23 520.2 | | 26 050.3 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 109.6 | 7 338.5 | - | 7 228.9 |
| **Томилолт, зочны зардал** | 183.2 | - | | 183.2 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 200.0 | 432.0 | - | 232.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30 807.9 | 33 773.5 | - | 2 965.6 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4 819.9 | 11 098.9 | - | 6 279.0 |
| Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 4 819.9 | - | | 4 819.9 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 11 098.9 | - | 11 098.9 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(9 118.6)** | **(22 972.6)** | | 13 854.0 |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(9 118.6)** | **(22 972.6)** | | 13 854.0 |

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан ямар нэгэн өөрчлөлт байхгүй.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 457139.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 457139.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 46703.4 мянган төгрөгөөр бууруулж 410436.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Коронавируст халдвар/ ковид -19/ цар тахалтай холбоотой анх батлагдсан төсвөөс хасаж тодотгол хийсэн 46703.4 , оны сүүлчээр зарцуулаагүй үлдэгдэл санхүүгийн дэмжлэгээ буцаан төвлөрүүлсэн 11098.9 бүгд 57802.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулаагүй байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 410436.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 357335.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэгээр, 53101.0 мянган төгрөгийг орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 410436.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 410436.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 399337.3 мянган төгрөгийг зарцуулж 38778.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 399337.3 мянган төгрөг буюу 97.3 хувьтай буюу 11098.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

| Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү |
|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 410436.2 | 399337.3 | 11098.9 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279683.5 | 279683.4 | 0.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37757.4 | 37491.7 | 265.7 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 51046.6 | 50424.0 | 622.6 |
| Хангамж, бараа материалын зардал | 596.0 | 631.1 | -35.1 |
| Нормативт зардал | 37413.0 | 27657.0 | 9756.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2054.4 | 1831.9 | 222.5 |
| Томилолт, зочны зардал | 123.7 | 123.0 | 0.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 575.6 | 559.6 | 16.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1186.0 | 935.5 | 250.5 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 410 436.20 | 399 337.27 | 11098.9 |
| Улсын төсвөөс санхүүжих | 53 101.00 | 52 018.17 | 1082.8 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 357 335.20 | 347 319.10 | 10016.1 |

- Нийгмийн даатгалын шимтгэл: 265.7 мянган төгрөгөөр хэмнэсэн нь анх төсөв төлөвлөхдөө нэг хувийн илүү тооцоололт хийгдсэн тул тухайн санд үлдээн буцаан төвлөрүүлсэн байна.
- Хоол хүнс 9756.0, урсгал засвар 222.5, бараа үйлчилгээний бусад зардал 250.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Ковид-19 буюу цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зарим сард ажиллаагүй, зарим сард хагас ажилласан, тайлант онд томилолтоор багш ажилтан яваагүй, зуны улиралд ээлжийн бүлэг ажиллаагүй зэрэгтэй холбоотой байна. Үүнээс : Шинээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд нийт зөрүүний 27.8 хувь буюу 13930.7 мянган төгрөг байна.

Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 28.3 хувь буюу 3884.0 мянган төгрөгийг түлшний хөнгөлөлтөд олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт дансаар аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас урсгал засварт зориулан 5593.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдэж, засвар хийж данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан. 151 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5162.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5162.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй .

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 5162.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах 2 асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн үеэр анхаарал хандуулж дахин хянаж хэрэгжилтийг нэгтгэн хянах шаардлагатай байна.Үүнд:

- *2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “ Окфил”агаар шүүгчийг суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэгт 30 ширхгийг 7 ангид 3390.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн,*
- *2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 380.0 мянган төгрөгийн маск нийлүүлэх гэрээ хийж Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн*
- *БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нотебүүкийг нэг бүрийг 1749500 төгрөгөөр 3499,0 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.*

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**<u>Нийгмийн даатгалын шимтгэл</u>**

1.1. *Илрүүлэлт:* 2020-12-21-ны цэцэрлэгийн эрхлэгчийн А/26 тоот тушаалаар хоол унааны хөнгөлөлт олгосон /3550,0*24хувь/ дүнгээс 825.0 мянган төгрөгийн НДШ тооцоогүй
1.2. *Эрсдэл:хууль , дүрэм , журам зөрчигдөх*
1.3. *Өгсөн зөвлөмж: 2021 оны эхний улиралд* 2020-12-21-ны цэцэрлэгийн эрхлэгчийн А/26 тоот тушаалаар олгосон хоол унааны хөнгөлөлт 3550,0 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, авлагын дүнгээсээ бууруулах
1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.*

***Нормативт зардал /Хоол /***

2.1 *Илрүүлэлт: Тайлант онд* нийт 8681 хүүхэд өдөрт 21031.9 мянган төгрөгний хоолонд зарцуулж нэг хүүхдэд 2423.0 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 52.2 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 453.6 төгрөгний хоол дутуу олгосон байна Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУЗГ-ын тогтоол зөрчсөн байна.
2.2 *Эрсдэл:хууль , дүрэм , журам зөрчигдөх*
2.3 *Өгсөн зөвлөмж:* Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот ‘’Хоолны зардлын норматив тогтоох тухай’’ тогтоолыг мөрдөх
2.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.*

***И-баримтын бүрдүүлэлт***

*3.1. Илрүүлэлт:* Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу байна.

*3.2. Эрсдэл*: тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах
*3.3. Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах
*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвшөөрсөн*

***Цалингийн зардал** /хоол, унаа, түлшний хөнгөлөлт/*
*4.1. Илрүүлэлт:*

Оны эцэст Коронавируст халдвар ковид-19-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 3884.0 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 25 албан хаагчдад олгосон байна.

*4.2. Эрсдэл*: төсвийн хөрөнгийг буруу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчих, төсвийн төлөвлөлт буруу төлөвлөх
*4.3. Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах
*4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын код:

| | | |
|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***Жаргалант сумын 11 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** |
| **2020** | | ХОА-2021/169/СТА- |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Жаргалант сумын 11 дугаар цэцэрлэг** | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу | | Зөвлөмж | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Ц.Тулга Б.Дамчуубалжир |
| 2 | Батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 3884.0 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 25 албан хаагчдад олгосон байна. | 3884.0 | Зөвлөмж | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Ц.Тулга Б.Дамчуубалжир |
| 3 | 2020-12-21-ны цэцэрлэгийн эрхлэгчийн А/26 тоот тушаалаар хоол унааны хөнгөлөлт олгосон /3550,0*24хувь/ дүнгээс НДШ тооцоогүй | 825.0 | Зөвлөмж | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Ц.Тулга Б.Дамчуубалжир |
| 4 | Тайлант онд нийт 8681 хүүхэд өдөрт 21031.9 мянган төгрөгний хоолонд зарцуулж нэг хүүхдэд 2423.0 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 52.2 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 453.6 төгрөгний хоол дутуу олгосон байна | 453.6 | Зөвлөмж | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Ц.Тулга Б.Дамчуубалжир |
| **ДҮН** | | **5162.6** | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР Огноо:2021. 02.24

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН Огноо:2021.02.24

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН ЗАХИРАЛ, АУДИТОР Д.ХИШГЭЭ

Огноо:2021. 02.24